



ДААТГАЛ  
SINCE 1994

"Ард Санхүүгийн Нэгдэл"-ийн байр 2 дугаар дахар,  
Ерөнхий сайд Амерын гудамж, Сүхбаатар дүүргэг,  
Улаанбаатар хот 14280, Монгол улс  
Утас: 7720 0088, И-мэйл: info@arddaatgal.mn

2020 он 5 сар 4 өдөр

Дугаар 8/25

Улаанбаатар хот


## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Аудитын хорооны дурмийг  
шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэг, 81 дүгээр зүйлийн  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 5 сарын 4-ний өдрийн эчнээ санал хураалтын  
шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Аудитын хорооны шинэчилсэн дурмийг хавсралгаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Аудитын хороодын  
гишүүд (З.Ариун, И.Сэр-Од, О.Одбаяр) болон Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн  
бичгийн дарга (Э.Гэрэлчимэг)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ГАНХУЯГ  

БАТЛАВ. ТУЗ-ИЙН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

АУДИТЫН ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Зорилго

1.1 ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны зорилго нь (1) байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, (2) санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодит байдал, (3) компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал, (4) хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох (5) Компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмж өгөх зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нехцэлийг бурдүүлэхэд оршино.

1.2 Аудитын хороо нь чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар санал, дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулах, хууль тогтоомжид заасан зарим асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байна.

Хоёр. Бүрэлдэхүүн

2.1 Аудитын хороо нь турваас доошгүй ТУЗ-ийн гишүүнээс бурдэх бөгөөд хорооны гишүүдийн 2/3-ос доошгүй нь хараат бус ТУЗ-ийн гишүүн байна.

2.2 Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд хорооны гишүүдийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, цалин урамшуулал, иэр дэвшүүлэх хорооноос санал болгож, ТУЗ-ийн хурлаар томилно.

2.3 Хорооны дарга, гишүүд нь дараагийн дарга, гишүүд албан ёсоор томилогдож, ТУЗ-еес хорооны гишүүнээс чөлөөлөх шийдвэр гартал ажил үүргээ гүйцэтгэнэ.

2.4 Хорооны гишүүн бүр нь санхүүгийн боловсролтой байх бөгөөд хамгийн багадаа нэг гишүүн нь санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн холбогдох хууль зүй ба зохицуулалтын хүрээнд “санхүүгийн шинжээч” байна.

Гурав. Хурал

3.1 Аудитын хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай нехцэлд нэмэлт хурлыг зохион байгуулж болно.

3.2 Хуралд гишүүдийн 2/3 нь оролцсоноор хүчин төгөлдөр болох ба гишүүд хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хурлыг гишүүд харилцан бие биенээ сонсож, санал бодлоо илэрхийлж болох

арга хэрэгслийг ашиглан цахим хэлбэрээр зохион байгуулах эсвэл хуралд оролцоогүй гишүүний саналыг бичгээр авсан байж болно.

3.3 Хорооны хуралд шаардлагатай тохижолдолд компанийн удирдлагууд болон ажилтнууд, гаднын зөвлөгчид, хараат бүс аудиторуудыг оролцуулж болно.

3.4 Хорооны дарга нь хорооны хурлцн тов, хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан тодорхойлох бөгөөд гишуудийн зүгээс хэлэлцэх асуудалд оруулах саналаа хурал хуралдахаас ажлын гурваас доошгүй хоногийн өмнө ирүүлж болно.

3.5 Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээ, материалыг урьдчилан гаргуулж, бүх гишүүд урьдчилан танилцсаны үндсэн дээр хэлэлцүүлэг явагдана.

3.6 Хороо нь хурлаар хэлэлцсэн асуудлынхаа хүрээнд дүгнэлт, зөвлөмж, удирдамж гаргаж, холбогдох дүрэм, журмыг батална.

## Дөрөв. Хорооны чиг үүрэг

#### **4.1 Хяналтын тогтолцоог бурдуулэх уурзг**

Аудитын хорбо нь компанийн санхүү, стратеги, уйл ажиллагаа, хуулийн мөрдөлт болон нэр хүндийн бүхий л хүрээг хамрах хяналтын тогтолцоог /дотоод, гадаад хянал/ бурдуулэх бөгөөд хяналтын тогтолцоо нь чадварлаг, шуурхай, мэргэшсэн, хараат бус, компанийн зохицтой ажиллагаа, үр ашгийг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, түүнийг эрсдэлээс сэргийлж чадаг байна. Энэ хүрээнд

4.1.1 Компанийн санхүүгийн тайланг шалгаж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагчанд бүрэн болон хэсэгчилсан шалгалт хийх хараат бус /хөндлөнгийн/ аудиторт тавигдах хараат бус байдлын болон мэргэшил, ажлын туршлага, бусад шалгуур үзүүлэлтийг тогтоож, хараат бус аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээ, бусад гэрээний нэхцэлийн талаар санал боловсруулан ТҮЗ-өөр шийдвэрлүүлэх;

4.1.2 Хараат бус аудиторын хараат бус байдал болон бусад шалгuur үзүүлэлтийг хангаж байгаа байдаад дүгнэлт хийн, бие даан шууд сонгож, аудитортой байгуулах гэрээг батлах, хараат бус аудитын үйл ажиллагаанд хяналт тавих, ажлын гүйцэтгэлийг унэлэх, гэрээг цушилах:

4.1.3 Хараат бус аудиторын дүгнэлт, тайланг хэлэлцэн шаардлагатай зүйлийг асууж тодруулах замаар асуудлын мөн чанарыг таниж мэдсэний үндсэн дээр хяналтын системийг бийтэйстроогүй болгох, урьдчилан сэргийлэх арга хэлбэрийг тодорхойлж, компанийн удирдлага, холбогдох албан тушаалтанд үүрэг, чиглэл өгөх, хараат бус аудиторын зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих;

4.1.4 Дотоод аудитын албаны удирдлага, ажилтны мэргэшил, ажлын туршлага, бусад шалгуур үзүүлэлт, ажлын үүрэг хариуцлага, цалин хөлсний хэмжээ, албаны үйл ажиллагааны жилийн төсөв зэргийг тодорхойлох;

- 4.1.5 Дотоод аудитын албаны удирдлага, ажилтныг томилох, ажлын төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийг үнэлэх, ажлаас чөлөөлөх;
- 4.1.6 Дотоод аудиторын шалгалтын үр дүн, тайланг биечлэн тавиулж, асуудлын мөн чанарыг таньж мэдсэний үндсэн дээр зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэлбэрийг тодорхойлж, компанийн удирдлага, холбогдох албан тушаалтанд үүрэг, чиглэл өгөх;
- 4.1.7 Компанийн гүйцэтгэх захирал болон байгууллагын удирдлагууд дотоод хяналтын ажлын хамрах хүрээ, ажлын чиг үүргийг ойлгож үр дүнтэй мэргэжлийн төвшинд хүргэхэд анхаарах;
- 4.1.8 Дотоод аудитын албаны гаргасан дүгнэлттэй танилцах, түүний дагуу хийгдсэн мөн хийгдэж буй ажлын үр дүнтэй танилцах.

#### *4.2 Компанийн үйл ажиллагаанд хяналт тасих чиг үүрэг*

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь гадаад дотоод хяналтын тогтолцоогоор дамжуулан компанийн үйл ажиллагаанд дараах чиглэлээр хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт гарган, гарсан зөрчил дутагдлыг арилгах талаар компанийн удирдлагад үүрэг, чиглэл өгч, хяналтын үйл ажиллагааны үр дүнгээ ТУЗ-д тайлагнаа.

- 4.2.1 Компанийн санхүү, үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх;
- 4.2.2 Компанийн санхүү, шийдвэр болох бүртгэлийн үзүүн зөв нутгийн байгаа эсэх, хийгдэж буй аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа байдал, санхүүтийн тайлан нь нягтлан бодох бүртгэл, санхүүтийн тайлангийн олон улсын стандартыг нийцэж байгаа эсэх;
- 4.2.3 Санхүү, татвар болон Санхүүгийн зохицуулах хорооноос хийсэн шалгалтын дүгнэлт, материалтай танилцах, тэдгээрт илэрсэн зөрчлийг арилгасан эсэх, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх;
- 4.2.4 Компанийн санхүүгийн удирдлага зохистой байгаа эсэх, хийгдэж байгаа гэрээ хэлцэл их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл болох эсэх;
- 4.2.5 Компанийн дотоод хяналт, журмуудын хууль, дүрэмд нийцсэн байдал, журмуудын хэрэгжилт;
- 4.2.6 Хөндлөнгийн аудитыг зохих ёсоор гүйцэтгэсэн эсэх;
- 4.2.7 Дотоод аудитын албаны үйл ажиллагаа зохистой байгаа эсэх;
- 4.2.8 Мэдээллийн ишээлттэй, ил тод байдал хангагдаж байгаа эсэх, гадаиш мэдээлж байгаа мэдээллийн үнэй зөв байдал, компанийн нууц болон дотоод мэдээлэл алдагдсан эсэх, түүнийг буруугаар ашигласан эсэх;

- 4.2.9 Компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагаа зохистой байгаа эсэх, хууль, дурэм, ёс зүйн хэм хэмжээг баримталж байгаа эсэхэд /зохисгүй үйл ажиллагааг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоо чадвартай байх/ тус тус хяналт тавих;
- 4.2.10 Байгууллагын бүтцийн ашигт ажиллагааг хянаж, үнэлж дүгнэх;
- 4.2.11 Хөндлөнгийн аудитортой хамтарч ажиллах;
- 4.2.12 ТУЗ-ийн хуралд танилцуулах мэдээллийн үнэн зөв байдлыг хянах;
- 4.2.13 Байгууллагын эрсдэлийн бүртгэл болон үнэлгээг гаргаж байх;
- 4.2.14 Гүйцэтгэх удирдлагын багас гаргаж буй санхүү болон үйл ажиллагаатай холбогдолтой дурэм, журмыг шалгаж хэрэгжилт, ач холбогдол, үр ашгийг үнэлж байх;
- 4.2.15 Удирдлагууд тодорхойлсон эрсдэлийг эрэмбэлж хариуцах ажилтанд үүрэг даалгавар өгч түүний хяналтыг зөв зохистой хийж байгааг шалгах;
- 4.2.16 Байгууллагад учирч болох үйл ажиллагаа, ажилчдын аюулгүй байдал, нэр хүнд, санхүүгийн сөрөг нэдээг Монгол улсын хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон байгууллагын дурэм, журам, төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэхийг үнэлж дүгнэлт гаргах;
- 4.2.17 Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлийг шалгаж түүний үр ашгийг үнэлэх;
- 4.2.18 Байгууллагын нэр хүндийн судалгаа хийж түнд дүгнэлт гаргах;
- 4.2.19 Байгууллагын хэрэгжүүлж буй төсөл болон арга хэмжээ төлөвлөсөн зорилгодоо хүрч байгаа эсэх дээр дүгнэлт хийх;
- 4.2.20 Аудитын хороо болон ТУЗ-ийн хүсэлтийн дагуу нэмэлт дотоод хяналтыг хийх.

#### **4.3 Тайлagnalын үүрэг**

Аудитын хороо нь үйл ажиллагаагаа ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлagnана.

- 4.3.1 Дотоод, гадаад хяналтын тогтолцоогоор илэрсэн аливаа зөрчил, дутагдал болон тэдгээрийг арилгах арга хэмжээний талаар ТУЗ-д байнга тайлagnах;
- 4.3.2 Аудитын хорооны хурлын тэмдэглэл, шалгалтын тайлан, дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах;
- 4.3.3 Хорооны гишүүдийн танилцуулга, намтар, хорооны үйл ажиллагааны жилийн тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах;
- 4.3.4 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн бол дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах.

#### **4.4 Компанийн нууцыг хадгалах үүрэг**

4.4.1 Хорооны гишүүд нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан компанийн зүгээс танилцуулсан эсвэл шалгалтаар илрүүлсэн аливаа нууц болон дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүдиэс ашиглахгүй байх, шууд болон шууд бус байдлаар бусдад задруулахгүй байх, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй.

**Тав. Эрх мэдэл**

Аудитын ҳороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдон дараах эрхтэй байна.

5.1. Хараат бус аудитын байгууллагыг томилох, төлберийн хэмжээг тогтоох болон ажлыг нь шалгах, гэрээг цуцлах;

5.2 Дотоод аудиторыг томилох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох, тодорхой асуудлаар хяналт шалгалт хийхийг даалгах, ажлын гүйцэтгэлтэй танилцах, гүйцэтгэлийг үнэлэх, ажлаас чөлөөлөх;

5.3 Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар компанийн удирдлагад үүрэг даалгавар, заавар зөвлөмж өгөх;

5.4 Шаардлагатай үед хөндлөнгийн аудитор, хөндлөнгийн шинжээч, мэргэжилтнүүд /нягтлан бодогч, хуульч тэх мэтийн зөвлөгөө, туслалцааг авах, тодорхой асуудлын хурээнд хөлсөөр ажиллуулах;

5.5 Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

5.6 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахыг шаардах, түүгээр хэлэлцэх асуудлыг санал болгох;

5.7 Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргах, зөрчил гаргасан бол түүнийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг ТУЗ-д оруулах;

5.8 Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангуулах, шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримтыг саадгүй гаргуулах, холбогдох мэдээллийг гаргаж өгөөгүй ажилтан албан хаагчдад хариуцлага тооцох саналыг гүйцэтгэх удирдлагад оруулах.

**Зургаа. Дүрэмд өөрчлөлт оруулах**

6.1 Хороо нь энэхүү дүрмийн чиглүүлэцүүдийг нэмэртэй, нарийнтийн түүүлийн шаардлагатай гэж үзвэл ТУЗ-д санал оруулж батлуулж болно.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**